



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 06

Өлгий

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах  
зарим арга хэмжээний тухай

Улсын хэмжээнд 2017 онд 13 аймгийн 70 сум, нийслэлийн 5 дүүрэгт нийт 225 удаагийн ой, хээрийн гал түймэр гарч 120.9 мянган га ой, 446.5 мянган га хээр, нийт 587.4 мянган га талбай өртөж, иргэд, аж ахуйн нэгжийн өмч хөрөнгөнд 77.7 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Түймрийн нөхцөл байдлын 2016 онтой харьцуулахад түймэрт хүний амь нас эрсдээгүй, түймэрт өртсөн эд материалын хохирол, түймэрт өртөж шатсан талбайн хэмжээ буурсан боловч, түймрийн тоо 63 хувь, байгаль экологид учирсан хохирол 5.3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Цаг уур, орчны шинжилгээний газраас 2018 оны 3, 4, 5 дугаар саруудад нийт бүс нутгаар хуурайшилт эрчимтэй явагдаж, олон жилийн дунджаас илүү халж, хур тунадас багатай гэсэн цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ ирүүлсэн нь эрсдэл өндөр байхыг харуулж байна.

Иймд Улсын Онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газрын даргын “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 2018 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах, аймаг, орон нутгийн хэмжээнд ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх зорилгоор дараах **АЛБАН ДААЛГАВРЫГ** хүргүүлж байна.

Нэг: Сумдын Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга нарт ДААЛГАХ нь:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Ойн тухай хууль, Засгийн газрын 1999 оны 55, 2001 оны 98, 2013 оны 106 дугаар тогтоолын хэрэгжилтийг 2018 оны 05 дугаар сарын 01-ний дотор шалган, бэлтгэл бэлэн байдлыг хангуулж ажиллах;

2. Монгол Улсын Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.8, 18.2.10, 18.2.14, 18.15 дугаар зүйлүүдийг хэрэгжүүлж ажиллах;

00000004

3. Багийн Засаг дарга болон байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нарын түймэр гарах магадлалтай нутаг дэвсгэрт тавих хяналт шалгалтыг сайжруулах, эргүүл, хяналтын байршлыг оновчтой сонгож хөдөлгөөнт болон байнгын постуудыг ажиллуулах;

4. Зарим гол зам даваа, уулын амыг нутгийн иргэдэд гэрээгээр хариуцуулж, шаардлагатай тохиолдолд унаагаар хангах арга хэмжээг авах;

5. Хавар, намрын улиралд ойгоос мод бэлтгэх, ойн дагалдах нөөцийг ашиглах, аялал зугаалгаар явах зэрэг үйл ажиллагааг Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.17-д заасны дагуу ой, хээрийн түймэр гарах байгалийн нөхцөл бүрдсэн хуурайшилт бүхий 3 дугаар сарын 20-ноос 6 дугаар сарын 10, 9 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны хооронд хязгаарлах талаар сумын Засаг даргын захирамж гарган хэрэгжилтэд нь хяналт тавьж, үр дүнг нь тооцон ажиллах;

6. Түймэр гарсан үед 24 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг эхний ээлжинд явуулж, хоёр, гурав дахь ээлжийн хүн хүч, техник хэрэгслийг бэлтгэж, бэлэн байдлыг хангуулж ажиллах;

7. Ой, хээрийн түймрийн шалтгаан нөхцөл түймэр гаргасан этгээдийг олж илрүүлэх, хариуцлага тооцох ажлыг шуурхай зохион байгуулах;

8. Сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн удирдлага, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний шуурхай ажиллагаа, бэлтгэл бэлэн байдлыг хангуулж ажиллах;

9. Сумын Онцгой комисс, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн удирдлага, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн, иргэдийг ой, хээрийн түймрийг унтраах зориулалтын багаж хэрэгсэлтэй болгох, өөрсдөөр нь хийлгэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах, түймэртэй тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг хангуулах;

10. Сум, багийн иргэдэд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ, түймрийн хор уршиг, хохирлын талаар сургалт явуулах;

11. Ой, хээрийн түймэр гарсан тохиолдолд дайчлагдан ажиллах хүн хүч, машин техник, хоол хүнсний тооцоог урьдчилан тодотгож бэлэн болгох;

12. Энэхүү албан даалгаврын биелэлтийг 2018 оны 05 дугаар сарын 20, 10 дугаар сарын 20-ны дотор тус тус аймгийн Онцгой байдлын газарт ирүүлэхийг сум, албан газар, аж ахуйн нэгж байгууллагын дарга нарт үүрэг болгох;

13. Түймэр гарсан тухай мэдээ мэдээллийг шуурхай, үнэн зөв, тодорхой хүлээн авч аймгийн Онцгой байдлын газрын 7042-101, 94495101, 89544101 дугаарын утсанд мэдээлж байх.

Гурав: Байгаль орчин, аялал жуулчалын газрын дарга /Д.Айбек/, Монгол алтай нурууны улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга /С.Медеухан/ нарт ДААЛГАХ нь.

1. Ойн сан бүхий газартай хиллэж байгаа хөдөө аж ахуйн болон бусад ангиллын газруудаар ой, хээрийн түймрээс хамгаалах хамгаалалтын шороон зурвас байгуулах, сэргээх ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлээр сум, багийн Засаг дарга нартай хамтран ажиллах.

2. Хэт их хуурайшилттай улиралд ойгоос мод бэлтгэх, ойн дагалдах нөөц ашиглах, аялал зугаалгыг хязгаарлах тухайн сум, багийн Засаг дарга, ойн анги, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нарыг нутаг дэвсгэрийн хэмжээнд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах хөдөлгөөнт эргүүл, постуудыг ажиллуулах талаар хамтран ажиллах.

3. Ойн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу албан газар, аж ахуйн нэгж байгууллагууд, нөхөрлөлийн гишүүд, иргэдэд түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар ухуулга, сургалт, сурталчилгааг зохион байгуулж явуулах.

4. Сумдын байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч, ойн ангийн бие бүрэлдэхүүнийг хариуцсан нутаг дэвсгэртээ тавих хяналтаа сайжруулах, эргүүл, хяналт шалгалтын ажлаа эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгч ажиллах.

5. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр анхааруулга сэрэмжлүүлгийг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр олон нийтэд хүргэх.

6. Тусгай хамгаалалттай газрыг ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар тодорхой ажлыг зохион байгуулах.

7. Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төрийн бус байгууллага, иргэд, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгжийн багаж техник, гар багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, судалгааг гарган түймэр унтраах дадлага сургалтыг аймгийн Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулах.

Дөрөв: Аймгийн Онцгой комиссын гишүүн, Цагдаагийн газрын дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батхүү/-д ДААЛГАХ нь:

1. Ой, хээрийн түймрийн шалтгаан нөхцлийг хуулийн хугацаанд шалган тогтоож, эзэн холбогдогчдод хариуцлага хүлээлгэх, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга, олон нийтэд мэдээлэх.

2. Аймгийн хэмжээнд цаг агаарын хуурайшилтын аюултай, нэн аюултай зэрэгт хүрсэн үед сумдын цагдаагийн бүрэлдэхүүн нь хариуцсан сумын байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нартай хамтран цагдаагийн эргүүл, хяналтын цэгийг байгуулах үүрэг чиглэлээр хангаж, тодорхой ажил зохион байгуулж ажиллах.

3. Хуурайшилттай өнөө үед хөдөө хээр, ногоон бүсэд зорчих тээврийн хэрэгслийн яндангийн оч хамгаалагчийг шалгах, ногоон бүсэд аялал зугаалга болон бусад үйл ажиллагааг явуулахгүй байх.

4. Ой, хээрийн түймрийн үед эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаа буюу хэргийн газар үзлэг хийх, гал түймэр гарсан тухай акт, шинжээчийн дүгнэлт гаргах, мөрдөн шалгах, гал түймрийн шалтгаан нөхцөл, эзэн холбогдогчийг тогтоох ажлыг шуурхай зохион байгуулах.

5. Цаг агаарын хуурайшилтын “нэн аюултай”, “аюултай” зэрэгт хүрсэн үед эргүүл хяналтын цэгийг Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулан ажиллуулж, ногоон бүсэд зорчих иргэд болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, техникийн галын аюулгүй байдлыг хангуулахад хяналт тавих.

Тав. Хилийн 0165 дугаар ангийн захирагч /хурандаа Б.Мөнхбат/-д нарт ДААЛГАХ нь:

1. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга ажиллагаанд хил хамаалах анги, заставт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг сургаж, бэлтгэх, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, албан даалгаврыг сурталчлах ажлыг зохион байгуулах.

2. Ой хээрийн түймрийн үед албан хаагчдыг түймэр унтраах ажилд татан оролцуулах, бие бүрэлдэхүүнийг шаардлагатай техник хэрэгслээр хангах.

Зургаа. Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн дарга /Н.Оспан/-д ДААЛГАХ нь:

1. Ой, хээрийн түймрээс сэргийлэх, хамгаалах талаар иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулах.

2. Дээд шатны байгууллагаас гаргасан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, албан даалгаврыг сурталчлах, түймэртэй тэмцэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар бодитой ажил зохион байгуулж ажиллах.

3. Орон нутагт үүссэн гамшгийн цагийн байдлын бодит мэдээ мэдээллийг иргэдэд үнэн зөв, шуурхай дамжуулах, хүргэх.

Долоо. Аймгийн Онцгой комиссын гишүүн, Мэргэжлийн хяналтын дарга /Б.Мухамед/-д ДААЛГАХ нь:

1. Ойн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Засгийн газрын 1999 оны 55, 2001 оны 98, 2013 оны 106 дугаар тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах, үр дүнг тооцох.

Найм. Аймгийн Онцгой комиссын орлогч, Онцгой байдлын газрын дарга /хурандаа С.Пүрэвсамдан/-д ДААЛГАХ нь:

1. Аймгийн Онцгой комиссын хурлаар Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.8, 18.2.10, 18.2.14, 18.15 дахь заалтыг үндэслэн ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх асуудлыг хэлэлцүүлэн төлөвлөгөө гарган батлуулж шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх.

2. Ой, хээрийн түймрээс сэргийлэх, хамгаалах арга хэмжээнд иргэдийг сургах, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, албан даалгаврыг сурталчлах түймрийг унтраах мэргэшсэн баг зохион байгуулж тэдний сургалт бэлтгэлийг хангах, түймэр гарсан тохиолдолд унтраах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллах

3. Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүний ой, хээрийн түймрийг унтраах техник, тоног төхөөрөмжийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах.

4. Ой, хээрийн түймрийн үед гамшгаас хамгаалах албад, тусгай төрөл мэргэжлийн ангийг удирдлагаар хангаж, шаардлагатай тохиолдолд Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын 1, 2 дугаар хавсралтыг хэрэгжүүлж ажиллах.

5. Ой хээрийн түймрийн үед шаардлагатай хүн, хүч, холбоо, автомашин техник багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, хоол хүнс, шатахууны бэлэн байдлыг хангуулах.

6. Уг албан даалгаврын хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож аймгийн Онцгой комисс, аймгийн удирдлагад мэдээлж ажиллахыг тус тус үүрэг болгосугай.

